



Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд эцгийн оролцоо ба сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаа

Жин Орчлон*

БНХАУ, ӨМӨЗО-ны Өвөр Монголын Багшийн Их Сургууль,
Сэтгэл судлалын тэнхим

*Холбоо барих зохиогч: Shugraa89@gmail.com

Хүлээн авсан: 2020.10.29

Хянагдсан: 2021.04.13

Зөвшөөрсөн: 2021.04.30

Хураангуй

Бага насны хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх явцад эцэг, эхийн оролцоо харилцан адилгүй байдгаас хүүхдийн хөгжилд үзүүлэх нөлөө нь улс орон бүрд ялгаатай байна. Бид Монгол, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Монгол гэр бүлүүд хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхэд эцгийн оролцоог судалж, хоёр орны таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд үзүүлэх нөлөөг тодорхойлов. Судалгаанд Монгол, Өвөр Монголын Өөртөө засах орны нийт 205 хүүхдүүд, эцэг эхчүүдийг хамруулж, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал ба эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлийн оролцооны байдлыг шалгуураар үнэлсэн болно. Судалгааны үр дүнд дээрх хоёр орны эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцсон байдал харилцан адилгүй, оролцооны зарим үзүүлэлт нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд эерэг үр нөлөөтэй байна. Тухайлбал, Өвөр Монголын Өөртөө Засах орны хувьд эцэг, эхчүүдийн хурал, цэцэрлэгийн бусад үйл ажиллагааны оролцоо нь хүүхдийн танин мэдэхүйн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай эерэг холбоо хамааралтай байна. Судалгаанд хамрагдсан Монгол эцгүүд хүүхдийнхээ өдөр тутмын амьдралд илүү анхаарч, хүүхэдтэйгээ хамт байх нь хүүхдийн бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай эерэг үр нөлөөтэй байна.

Түлхүүр үг

Таван настай хүүхэд, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүй, Монгол, Өвөр Монгол

Удиртгал

Монголчууд үг дуу цөөнтэй, гэр бүлийнхээ нөмөр болж салхи шуурганаас хамгаалж явсан аавыгаа “уул” хэмээн оноож зүйрлэдэг. Эцэг хүний үг дуу багатай, хайр нь дотно байдаг дүр нь соёлын орчинд хүлээн зөвшөөрөгдсөн “үнэн” байлаа. Ялангуяа адил бус хүйсийн нийгэмд эзлэх байр суурь, биелүүлэх үүрэг хариуцлага нь ялгаатайгаас шалтгаалан эрчүүдийг “Талх ологч (Bread earner)” хэмээдэг бол үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх төв нь эмэгтэйчүүд гэх хэвшмэл буюу тогтсон хэв

шинжит ойлголт бий болсон. Гэвч сүүлийн үед эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хүйсийн тэгш байдлыг эрхэмлэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил ажил үйлсээ хөөцөлдөх болсон нь хойч үеэ өсгөж хүмүүжүүлэх үүрэг нь эцэг, эхчүүд адил тэгш болсон. Түүнчлэн “эцэг-хүүхэд”, “эх-хүүхэд”-ийн харилцаа хүүхдийн хүмүүжил, төлөвшилд адил чухал ач холбогдолтой нь батлагджээ.

Гэр бүл нь хүүхдийн хөгжилт төлөвшилд чухал ач холбогдолтой хэмээн судлаач нар үздэг. Хүний хөгжил төлөвшлийн чухал үе нь 0-18 нас гэж үзвэл нялх хүүхэд ба ээжийн хоорондох ээнэгшил, гэр бүл буюу эцэг, эхчүүд нь хүүхдээ сургуульд бэлтгэх ба нийгмийн гишүүн болгон бэлтгэх явц зэрэг нь хүний хөгжил төлөвшлийн чухал үе шатууд юм. Эх-хүүхдийн харилцааг олон судлаачид судалсан байдаг хэдий ч хүүхдийн хөгжлийн явцын “эцэг-хүүхдийн” харилцааны тухай судалгаа хомс төдийгүй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд эцгийн оролцоог үнэлэх шаардлага бий болсон. Эцгийн оролцоог хүүхдээ асран харгалзах, гэр бүлийн орчинд хүмүүжүүлэх үйл, сургууль цэцэрлэгийн орчинд хүмүүжүүлэх үйл болон хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг зэрэг 4 талаас судалсан. Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн гэсэн гурван чиглэлээр үнэлсэн болно. Иймд судалгаанд цуглуулсан тоон өгөгдлөө статистикийн боловруулалт хийж хоёр орны эцгийн оролцооны ялгаа ба хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд үзүүлэх нөлөөг илрүүлэхэд судалгааны ажлын зорилго оршино. Энэхүү зорилгыг үндэслэн судалгааны таамаглалыг **H₁**: судалгаанд хамрагдсан хоёр орны эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцох байдлын онцлог ялгаатай, **H₂**: судалгаанд хамрагдсан хоёр орны эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцох байдал нь хүүхдийн бие бялдрын хөгжил, (**H_{2a}**), танин мэдэхүйн хөгжил, (**H_{2б}**), нийгэмшихүйн хөгжил, (**H_{2в}**) сургуульд бэлтгэгдсэн байдалтай статистикийн холбоо хамааралтай хэмээн дэвшүүлж байна.

Судлагдсан байдал

Гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжил хүмүүжилд эцэг, эхчүүдийн нөлөө, хоорондох уялдаа холбоог эрдэмтэн судлаачид судалсаар байна. Үүнд 1975 онд АНУ-судлаач Lamb “Хүүхдийн хөгжилтөд мартагдсан хувь нэмэр оруулагч” (Forgotton contributors to child development) бүтээлд эцэг нь хүүхдийн хөгжил, хүмүүжилд үзүүлэх нөлөөний тухай судалгааны үр дүнг танилцуулсан байдаг. Эцэг, эхчүүд хүүхдийн хөгжил, хүмүүжилд тэгш бус хэлбэрээр хувь нэмрээ оруулж байна. Эцэг, эхийн сэтгэл зүйн нөхцөл байдал, гэр бүлийн хүчин зүйл, нөлөөлж буй бусад хүчин зүйл зэрэг гурван хэмжээсээр эцэг нь хүүхдийн хөгжилтөд үзүүлэх нөлөөг эхчүүдийнхээс ялгаж тодорхойлсон байна (Lamb, 2000, х.23). “Эцэг нь хүүхдээ асран хамгаалах, хүүхдийг тоглоомын үйл ажиллагаанд байнга оролцдог” (Clarke-Stewart.K.A, 1978, х.466). “Гэр бүлтэйгээ байнга хамт байж чаддаг эцгүүд хүүхдээ илүү сайн асран харгалздаг, энэ нь хүүхэд асрах туршлагын хуримтлалаас шалтгаалсан байх магадлалтай юм” (Pleck, 1997, х.66) гэжээ. Эцгийн оролцоо, дэмжлэг, тэдний сэтгэл хангалуун байхад хүүхдийн зан үйл, нийгэмшихүйн хөгжилтөд чухал ач холбогдолтой” (M.Black, Dubowitz, & Raymond H.Starr, 1999, х.96). “Африк гаралтай Америк хүүхдийг судалснаар эцгийн оролцоо хүүхдийн танин мэдэхүйн хөгжилтөд сайн үр нөлөөтэй юм. Тухайлбал, хүүхдийн сурлагын үр бүтээмж, хүүхдийн нийгэмшихүйн хөгжил төлөвшилтийг дэмждэг байна” (Coley, 2001, х.743). “Хүүхэдтэйгээ хамт тоглох тохиолдолд эцгийн оролцоо нь хүүхдийн танин мэдэхүйн чадварыг хөгжүүлж байна” (Shannon, Tamis-LeMonda, London, & Cabrera, 2002, х.77). “Эцэг, эх

хамтран хүүхдээ асарч хүмүүжүүлэх үйлд идэвхтэй оролцох нь таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд эерэг нөлөөтэй” (Ren, Cheung, Boise, Li, & Fan, 2020, х.77). “Эцэг, эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэх үйлд илүү оролцох тусам хүүхдийн хэл ярианы хөгжлийн түвшин илүү өндөр байдаг” (Suh, 2019, х.1). “Эцгийн боловсролын түвшин өндөр байх тусам хүүхдээ асарч хүмүүжүүлэхэд илүү хариуцлагатай байдаг. Хүүхэд насны эрт үед эцэг нь хүүхдээ илүү асарч харгалзах нь хүүхдийн олон талын хөгжилтөд сайн нөлөөтэй” (Sar & Listiana, 2019, х.1139). Судлаачдын бүтээлээс харахад хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд эцгийн оролцоо нь хүүхдийн бие бялдар, оюун ухаан болон сэтгэл нийгэмшихүйг хөгжүүлэх хандлагатайг харж болно.

Судалгааны хамрах хүрээ


Монгол улсын хувьд Улаанбаатар хотын ХУД-ийн яармагийн 229 дүгээр цэцэрлэг, Баянгол дүүргийн МУБИС-ын харьяа 249 дүгээр цэцэрлэг, 87 дугаар цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 221 дүгээр цэцэрлэг ба 246 дүгээр цэцэрлэгийн нийт 105 хүүхдүүд, эцэг, эхчүүд, ӨМӨЗО-ны Шилийн-гол Аймгийн Шилийн Хот дахь хоёрдугаар цэцэрлэг, Монгол цэцэрлэгийн нийт 100 хүүхэд, эцэг, эхчүүд буюу нийт 205 хүүхэд, 205 эцэг, эхчүүдийг энэхүү судалгаанд хамруулсан.

Судалгааны арга зүй

Уг судалгаанд таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын хүүхдийн цогц хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэн бие бялдрын, танин мэдэхүй буюу оюун ухаан, нийгэмшихүйн хөгжилт хэмээх гурван хэмжээсээр авч үзсэн. Бие бялдрын хөгжлийг үнэлэх 6 даалгавар, оюун ухаан буюу танин мэдэхүйн хөгжлийг үнэлэн 9 даалгавар, нийгэмшихүйн хөгжлийг үнэлэх 7 даалгавар, нийт 22 даалгавар бүхий шалгуурыг 205 хүүхдүүд дээр туршин хийж гүйцэтгэсэн. “Хүүхдийн гүйцэтгэлд оноо өгөх баримжаа: нэг даалгавар зөв гүйцэтгэсэн тохиолдол 2 оноо, хагас биелүүлсэн бол 1 оноо, биелүүлж чадахгүй бол 0 оноо. Нийт оноо 44 ” (Мин, 2019, х.35).

Зураг 1

Хүүхдийн цогц хөгжил



Үүний дагуу “Гэр бүлийн нөхцөл байдлын тухай асуулга” хэмээх 11 асуулттай асуулгын хуудсаар эцгийн оролцоог үнэлсэн болно. Судалгаанд цуглуулсан тоон өгөгдлийг SPSS программаар анализ хийж, kendall b корреляци коэффициент


аргаар хоёр групп хэмжигдэхүүний нэг групп нь нэрийдсэн хувьсагч (жишээ нь: хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн адил бус төрөл) байх тохиолдолд spearman/ pearson корреляциас илүү kendall b корреляци коэффициентийг сонгон тооцсон болно.

Судалгааны үр дүн

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлийн эцгийн оролцоог дөрвөн хэмжээс, 11 асуултаар үнэлж, таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг судалсны дүнд:

График 1

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд эцгийн оролцсон байдал




Хүүхдээ асран харгалзахад хоёр орны хувьд Монгол эцгийн 57.3% нь хүүхдээ хувцаслуулж, хоол ундыг бэлтгэж өгөхөд идэвхтэй (байнга+ үлэмж) оролцдог бол Өвөр Монгол эцгийн 43.2% нь “байнга” буюу “үлэмж” хэмээх сонголтын хувилбарт нэгдсэн байна. Тиймээс хүүхдээ хувцаслах, хоол ундыг бэлтгэж өгөх зэрэг асран харгалзах үйлийн оролцооны хувьд Монгол эцэг илүү идэвхтэй байна. Иймд эцгийн оролцоо илүү идэвхтэй байхад хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж онооны үзүүлэлт илүү өндөр болох хандлагатайг график 2-г харуулав. Хүүхдийн өрөөг цэвэрлэж, хүүхдийнхээ хувь хүний ариун цэвэрт нь анхаардаг байдлыг харьцуулж үзэхэд, судалгаанд хамрагдсан Монгол эцгийн үргэлж (байнга+ үлэмж) оролцоо нь 55.8%, Өвөр Монгол эцгийн оролцоо 56.8% байгаа нь хоёр орны эцгийн оролцоо ялгаагүй, гэвч Монгол улсын хувьд эцгийн оролцооны байдал болон хүүхдийн бие бялдар, танин мэдэхүйн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж онооны хоорондох холбоо хамаарал нь статистикийн ач холбогдолтой, бие бялдын корреляци коэффициент нь kendall b= .176*, p=.049, танин мэдэхүйн дундаж онооны корреляци коэффициент нь kendall b=.174*, p=.045. Энэ нь эцэг нь хүүхдийнхээ хувь хүний ариун цэвэр зэрэгт илүү анхаарах нь түүний бие бялдын болон танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалд эерэг үр нөлөөтэй.

Хүүхдэдээ хувцас, тоглоом зэрэг авч өгөх байдлыг үнэлсний үр дүнд, судалгаанд хамрагдсан Монгол эцгийн “үргэлж ” сонголтын хувилбарт нэгдсэн нь 78.4% хүрсэн бол Өвөр Монголын хувьд энэ нь 66.3% болно. Үүнд Монгол эцгийн оролцоо нь хүүхдийн бие бялдын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноотой статистикийн холбоо хамааралтай, kendall b=.233**, p=.009 байна. Тухайлбал, эцэг нь хүүхдэдээ хувцас, тоглоом, бичиг хэрэгсэл авч өгөх нь хүүхдийн бие бялдын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалд эерэг үр нөлөөтэй болно.

График 2

СББ-ын дундаж оноо ба эцгийн оролцоо



Хүүхэдтэйгээ хамт байх цагийг ашиглах тухай бодитой судалж үзсэний дүнд эцэг нь хүүхдэдээ үлгэр түүх ярьж өгөх байдал нь Өвөр Монгол эцгийн 54.8% нь (байнга+ үлэмж сонголтын хувилбар) идэвхтэй оролцож байгаа бол Монгол эцгийн хувь нь 31.6% болно. Хүүхэдтэйгээ хамт кино үзэж, цэцэгт хүрээлэнд зугаалдаг байдлын хувьд судалгаанд хамрагдсан Монгол эцгийн 38.9% нь үргэлж (байнга+үлэмж) оролцдог бол Өвөр Монгол эцгүүдийн энэхүү оролцоо нь 79.4% байна. Хүүхэдтэйгээ хамт биеийн тамирын үйл ажиллагаанд (хөл бөмбөг тоглох, сагс тоглох зэрэг) оролцсон байдлыг үнэлсний үр дүнд, судалгаанд хамрагдсан Монгол эцгийн оролцоо нь зөвхөн 19% бол Өвөр Монгол эцгийн оролцоо нь 43.5% байна. Хоёр орны эцгүүдийн хүүхэдтэйгээ хамт биеийн тамирын үйл ажиллагаанд оролцох байдал тааруу байна. Үүнд Монгол улсын хувьд эцгийн оролцоо илүү идэвхтэй болох тусам хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноо өндөр байгаа нь ажиглагдав. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдээ хүмүүжүүлэх үйлийн оролцоог үнэлэх нэгэн чухал үзүүлэлт болох: Эцэг нь хүүхдээ цэцэрлэгт хүргэх буюу цэцэрлэгээс авах байдлаас харахад, Монгол эцгийн бараг хагас илүү хувь (53.7%) нь үргэлж оролцдог бол Өвөр Монгол эцгийн оролцооны хувь нь 71.6% байна. Гэвч эцэг нь хүүхдээ хүргэж тосдог байдал нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд нөлөөлөөгүй болно. Эцэг, эхийн хурал буюу цэцэрлэгийн бусад үйл ажиллагаанд оролцдог байдлыг үнэлсэн судалгаанд Монгол эцгийн оролцоо нь 43.1% бол Өвөр Монгол эцгийн оролцооны хувь нь 44.2%, хоёр орон бараг ялгаагүй харьцангуй тааруу байна. Гэвч Өвөр Монголын хувьд эцгийн энэхүү оролцооны байдал нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай сөрөг холбоо хамааралтай, Kendall $b = .217^*$, $p = .012$ байна. Тухайлбал, эцэг эхчүүдийн хурал буюу цэцэрлэгийн бусад үйл ажиллагаанд эцгийн оролцох байдал нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалтай статистикийн холбоо хамааралтай байна. Хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийг үнэлэх гурван үзүүлэлтийг авч үзэхэд, эцэг нь хүүхдэдээ байнга хань болдог байдлыг харьцуулан судалбал, судалгаанд хамрагдсан Монгол эцгийн хувь нь 54.7% бол, Өвөр Монгол эцгийн хувь нь 72.6% байна. Иймд хүүхдэдээ үргэлж хань болж байгаа тохиолдолд хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноо нь илүү өндөр оноо байх хандлагатай байгааг харж болно.

Даваагаас Баасан гарагт буюу ажлын өдөрт эцэг нь хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийн хувьд 68.4%-ийн судалгаанд хамрагдсан Монгол эцэг нь хүүхэдтэйгээ 2 цагаас илүү хамт өнгөрүүлж байгаа бол Өвөр Монгол эцгийн энэхүү хувь нь 40.4% болно. Тиймээс Даваагаас Баасан гарагт Монгол эцэг хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цаг нь Өвөр Монгол эцгээс харьцангуй илүү байна.

Энэ нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноотой статистикийн холбоо хамааралтай, kendall $b = .195^*$, $p = .026$ байна. Тухайлбал, ажлын өдөрт эцэг нь хүүхэдтэйгээ илүү хамт байж чадвал хүүхдийн оюун ухааны хөгжил төлөвшилд илүү ач холбогдолтой болохыг харж болно. Бямба, ням гараг буюу амралтын өдөр эцэг нь хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийг үнэлсэн судалгаанд 2 цагаас илүү хамт өнгөрүүлдэг Монгол эцэг нь 75.8% бол Өвөр Монгол эцгийн хувь нь 58.7% байна. Монгол эцгийн хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг нь харьцангуй илүү байх нь ажиглагдав. Үүнд амралтын өдөрт хамт өнгөрүүлэх цаг нь илүү байх тусам хүүхдийн бие бялдрын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноо нь даган өндөр болох хандлагатай, статистикийн холбоо хамаарал нь kendall $b = .210^*$, $p = .021$ байна. Энэ нь амралтын өдөрт эцэг нь хүүхэдтэйгээ хамт байх цаг нь хүүхдийн бие бялдрын хөгжилд эерэг үр нөлөөтэй гэдгийг тоон өгөгдлөөр баталсан болно.

Хүснэгт 1

СББ-ын дундаж оноо ба эцгийн оролцооны холбоо хамаарал (Монгол)

Kendall b	Асуулт	ББ	ТМ	Н	Асуулт	ББ	ТМ	Н
Correlation	Асуулт 22	.134	.078	.120	Асуулт 28	.036	.089	-.121
Sig. (2-tailed)		.127	.362	.184		.687	.302	.184
Correlation	Асуулт 23	.046	.027	-.053	Асуулт 29	.176*	.174*	.000
Sig. (2-tailed)		.611	.755	.563		.049	.045	1.000
Correlation	Асуулт 24	.087	.010	-.084	Асуулт 30	.233**	.126	.030
Sig. (2-tailed)		.331	.905	.361		.009	.145	.740
Correlation	Асуулт 25	-.005	.060	-.039	Асуулт 31	.116	.195*	.077
Sig. (2-tailed)		.955	.490	.668		.199	.026	.406
Correlation	Асуулт 26	.028	.153	.053	Асуулт 32	.210*	.133	.067
Sig. (2-tailed)		.754	.078	.562		.021	.134	.472
Correlation	Асуулт 27	.097	-.011	-.121		.036	.089	-.121
Sig. (2-tailed)		.274	.901	.184				

Тайлбар: СББ-сургуульд бэлтгэгдсэн байдал, ББ-бие бялдар, ТМ- танин мэдэхүй, Н- нийгэмшихүй


Хүснэгт 2

СББ-ын дундаж оноо ба эцгийн оролцооны холбоо хамаарал (Өвөр Монгол)

Kendall b	Асуулт	ББ	ТМ	Н	Асуулт	ББ	ТМ	Н
Correlation	Асуулт 22	.036	.025	.016	Асуулт 28	-	.217*	-.021
Sig. (2-tailed)		.683	.773	.860		.991	.012	.823
Correlation	Асуулт 23	.077	-.073	.146	Асуулт 29	.017	-.037	-.036
Sig. (2-tailed)		.390	.399	.117		.849	.668	.701
Correlation	Асуулт 24	.083	-.005	.058	Асуулт 30	.008	-.088	-.112
Sig. (2-tailed)		.359	.955	.536		.924	.310	.233
Correlation	Асуулт 25	.016	-.082	-.054	Асуулт 31	.091	.059	.043
Sig. (2-tailed)		.856	.348	.569		.313	.498	.649
Correlation	Асуулт 26	-.026	-.072	.008	Асуулт 32	.043	.014	.003
Sig. (2-tailed)		.770	.408	.935		.643	.874	.972
Correlation	Асуулт 27	.009	-.130	.036				
Sig. (2-tailed)		.918	.133	.697				

Зураг 2

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд эцгийн оролцоо ба хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын холбоо хамаарал



Хэлэлцүүлэг

Иймд хоёр орны судалгаанд хамрагдсан эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцсон байдал ялгаатай байна. Монгол эцэг нь хүүхдийн өдөр тутмын амьдралын хувьд хүүхдээ хувцаслуулах, хоол ундыг бэлтгэж өгөх, хүүхдэдээ хувцас, тоглоом, бичгийн хэрэгсэл худалдан авч өгөх, ажлын өдөр, амралтын өдөр хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг зэрэг илүү идэвхтэй оролцсон бол Өвөр Монгол эцэг нь хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийн зохистой ашиглах талаар жишээлбэл, хүүхдэдээ үлгэр түүх ярьж өгөх, байнга хань болох, хамт кино буюу цэцэгт хүрээлэнд тоглох, биеийн тамирын үйл ажиллагаанд оролцох, тэр дундаа хүүхдээ цэцэрлэгт нь хүргэж, авах зэрэг талуудад илүү идэвхтэй байна. Үүнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлийн оролцооны зарим зүйл нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд эерэг үр нөлөөтэй. Тухайлбал, судалгаанд хамрагдсан Өвөр Монголын эцэг нь эцэг, эхчүүдийн хуралд буюу цэцэрлэгийн бусад үйл ажиллагаанд оролцсон байдал нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай эерэг холбоо хамааралтай. Монгол улсын хувьд эцэг нь хүүхдийнхээ өрөөг цэвэрлэж, хүүхдийнхээ ариун цэвэрт нь илүү анхаарах нь хүүхдийн бие бялдрын, танин мэдэхүйн хөгжлийн сургуульд бэлтгэгдсэн байдалтай эерэг холбоо хамааралтай байна. Хүүхдэдээ хувцас, тоглоом авч өгөх нь хүүхдийн бие бялдрын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноотой холбоо хамааралтай. Ажлын өдөрт (Даваа-Баасан) эцэг хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг нь хүүхдийн танин мэдэхүйн хувьд сургуульд бэлтгэгдсэн

байдлын дундаж тоон өгөгдөлтэй статистикийн холбоо хамааралтай үр дүнд хүрсэн. Бямба, нямд буюу амралтын өдөрт эцгийн хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг нь илүү байх нь хүүхдийн бие бялдрын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноотой холбоо хамааралтай нь амралтын өдөрт эцэг нь хүүхэдтэйгээ хамт наадаж, тоглох боломж ихтэй учраас хүүхдийн бие бялдрын хөгжлийг ээргээр нөлөөлж байна хэмээн тайлбарлаж болно.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан Монгол эцэг нь хүүхдээ асран хүмүүжүүлж, өдөр тутмын амьдралд нь илүү анхаарах зэрэг онцлогтой бол Өвөр Монгол эцэг нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг хөгжүүлэх үйлд илүү оролцож байх онцлогтой юм. Энэ нь судалгааны хүрээнд дэвшүүлсэн таамаглал H_1 (судалгаанд хамрагдсан хоёр орны эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцох байдлын онцлог ялгаатай) баталсан болно.

2. Судалгаанд хамрагдсан Монгол эцэг нь хүүхдээ асран харгалзаж, хүүхэдтэйгээ хамт байх зэрэг үзүүлэлтүүд болон хүүхдийн бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай статистикийн ач холбогдол бүхий эерэг холбоо хамааралтай. Өвөр Монголын хувьд эцэг, эхчүүдийн хурал буюу цэцэрлэгийн бусад үйлд эцгийн оролцоо нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай статистикийн ач холбогдол бүхий эерэг холбоо хамааралтай, энэ нь судалгаанд дэвшүүлсэн: H_2 (Судалгаанд хамрагдсан хоёр орны эцгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцох байдал нь хүүхдийн бие бялдрын хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдал (H_{2a}), танин мэдэхүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай (H_{2b}) статистикийн холбоо хамааралтай) хэмээх таамаглалыг баталсан бол H_{2b} (эцэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих үйлд оролцох байдал нь түүний нийгэмшихүйн хөгжлийн хувьд сургуульд бэлтгэгдсэн байдалтай холбоо хамааралтай) таамаглалыг няцаасан болно.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг удирдаж, дэмжлэг үзүүлсэн доктор, профессор Ж.Батдэлгэр багшдаа талархал илэрхийлье.

Ном зүй

- Clarke-Stewart, K. A. (1978). And daddy makes three: The father's impact on mother and young child. *Child Development, 49*, 466-478.
- Coley, R. L. (2001). (In)visible men: Emerging research on low-income, unmarried, and minority fathers. *American Psychologist, 56*, 743-753.
- Lamb, M. E. (2000). The History of Research on Father Involvement. *Marriage & Family Review, 29*(2-3), 23-42. doi:10.1300/J002v29n02_03
- M. Black, M., Dubowitz, H., & Raymond H. Starr, J. (1999). African American Fathers in Low Income, Urban Families: Development, Behavior, and Home environment of their three-year-old children *Child Development, 70*, 96-978.
- Pleck, J. H. (1997). *Paternal involvement: Levels, sources and consequences*. Hoboken, New Jersey : John Wiley & Sons
- R. Moss. (1981). *Family Environment Scale Manual*. Washington, D.C : Consulting Psychologists Press.
- Ren, L., Cheung, R. Y. M., Boise, C., Li, X., & Fan, J. (2020). Fathers' perceived co-parenting and children's academic readiness among Chinese preschoolers: Longitudinal pathways through parenting and behavioral regulation. *Early*

- Childhood Research Quarterly*, 53, 77-75. doi:10.1016/j.ecresq.2020.03.005
Amsterdam, Netherlands: Elsevier
- Sar, M., & Listiana, A. (2019). *Father Involvement in Early Childcare: review of the literature*. Paper presented at the Proceedings The 2nd International Conference on Elementary Education. New York: Nova Science Pub
- Shannon, J.D., Tamis-LeMonda, C.S., London, K., & Cabrera, N. (2002). Beyond Rough and Tumble: Low-Income Fathers' Interactions and Children's Cognitive Development at 24 Months. *Parenting*, 2(2), 77-104. doi:10.1207/s15327922par0202_01 Oxfordshire: Routledge
- Suh, G. W. (2019). The influence of parenting on Korean children's language and school readiness: different roles of mothers and fathers depending on maternal employment. *Early Child Development and Care*, 1-13. doi:10.1080/03004430.2019.1658087 Oxfordshire: Routledge
- Мин, Ж. (2019). Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал ба эцэг эхчүүдийн боловсролын түвшний холбоо хамаарлын судалгаа. *Лавай*, 23. Mongolia: EDU press

Preschool Children's School Readiness and Father's Involvement

Ming Jin*

Department of Psychology, Inner Mongolia Normal University, Hohhot, China

*Corresponding author: Shugraa89@gmail.com 

Received: 10/29/2020/

Revised: 4/13/2021

Accepted: 4/30/2021

Abstract

In this study, the researcher used criteria and questionnaires to assess the school readiness of a total of 205 Mongolian and Inner Mongolian children aged 5-6 and the involvement of parents (mostly fathers) in the support of the child development. The participation of Mongolian and Inner Mongolian fathers in the development and upbringing of their children is different. For instance, Mongolian fathers are more involved in child care, while Inner Mongolian fathers are more involved in children's intellectual development. Some dimensions of child development interventions have a positive or negative effect on a child's readiness for school. For example, in Inner Mongolia, parental involvement in parent-teacher meetings or other kindergarten activities is negatively correlated with children's cognitive readiness for school. In Mongolia, a father cleaning his child's room and paying more attention to his child's hygiene has a positive relationship with the child's physical and cognitive readiness for school. Getting clothes and toys for the child is related to the child's physical fitness score. The amount of time a father spends with his child during the workday is related to the average score of the child's readiness for school. The fact that fathers spend more time with their children on Saturdays, Sundays, or weekends is related to the average physical fitness score of the child's school readiness.

Keywords

Father's involvement; school readiness; physical; cognitive; socialization
